



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2015 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/39

Мөрөн

Үр дүнгийн үнэлгээг баталж,  
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 31.1.1, Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2014 оны А/334 дүгээр захирамжаар батлагдсан журмын дагуу аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн 2014 оны үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг нэгдүгээр хавсралтаар, бусад байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг хоёрдугаар хавсралтаар, үр дүнгийн үнэлгээгээр шалгарсан агентлаг, байгууллагын үр дүнгийн үнэлгээний урамшуулалд олгох зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Урамшуулалд олгох 1 550 000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д, шалгарсан агентлаг, байгууллагын дарга нарын мөнгөн урамшууллыг тухайн байгууллагын төсвөөс зарцуулахыг Төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Г.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.ЭРДЭНЭБААТАР